МЭДЭЭ · 2020 оны 3-р сарын 9

СЭТГЭЛ ЗҮЙН БАГЦ СУРГАЛТЫН 2 ДУГААР ШАТНЫ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Дорноговь аймгийн прокурорын газраас прокурор, ажилтнуудын ажлын арга барил, хандлагыг өөрчлөх, санал, санаачлагыг дэмжих, хүний нөөцийг чадавхижуулах зорилгоор албан хаагчдад зориулсан сэтгэлзүйн багц сургалтыг "Итгэл, сэтгэл, хандлага" төрийн бус байгууллагатай хамтран үе шаттайгаар зохион байгуулж байгаа билээ.

Энэхүү багц сургалтын 2 дугаар шатны сургалтыг "Амжилтын ертөнц" сэдвээр энэ оны 3 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, амжилтын гол түлхүүр болох "Өөртөө итгэх итгэл"-ийн талаар харилцан ярилцжээ. Сургалтанд тус прокурорын газрын нийт прокурор, ажилтнууд хамрагдсан байна.

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3057